



ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 8/125

Дэлгэрхаан сум

Хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар тогтоолын 1.2, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоол, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан ан агнах, барих, арга хэмжээг үндэслэн сумын нутаг дэвсгэр болон тусгай хамгаалалттай газар нутагт Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Байгалийн нөөц ашиглсаны төлбөрийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай болон бусад хуулиуд, тэдгээрт нийцүүлэн хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулж ажилласугай.

2.Хяналт шалгалтын ажил зохион байгуулахад шаардагдах 241,120 (хоёр зуун дөчин нэгэн мянга нэг зуун хорин) төгрөгийг зарцуулсугай.

3.Хяналт шалгалтыг хуулийн дагуу, зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (У.Ариунтуяа), байгаль хамгаалагч (Х.Мөнхбат) нарт үүрэг болгосугай.

4.Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 1.1 дэх заалтын дагуу санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан (О.Анхцэцэг)-т захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д нарт даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2325010277



$\frac{20}{100}$ $\frac{50}{100}$ $\frac{200}{100}$
 نقص نصف ضعف

۱۹۰۰ - سر - ایضاً
 سر - ایضاً
 سر - ایضاً